



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/231

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 31 дүгээр дүгнэлтийг үндэслэн үерийн аюултай нөхцөлд явж байгаад эвдэрсэн Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 81-32 ХОУ улсын дугаартай Хантер маркийн УА3469 автомашины засвар үйлчилгээний зардалд 5.0 сая төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Автомашины засвар үйлчилгээнд зарцуулах 5.0 сая төгрөг /таван сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн байгалийн гамшгаас хамгаалах сангаас тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Зах-А/231/Ч  
02 01150

Аймгийн Засаг даргын 2019 оны  
04 дүгээр сарын 15-ны  
өдрийн А/231 дүгээр захирамжийн хавсралт



ҮЕНЧ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
АВТОМАШИНЫ ЗАСВАРЫН ЗАРДАЛ

ДД	Автомашины марк улсын дугаар	Эвдэрсэн эд анги	Тоо /ширхэг/	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	81-32 ХОУ улсын дугаартай Хантер маркийн УА3469	Хурдны хайрцаг /кроп/	1	5000000,00	5000000,00

-оОо-